



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 2018 оны "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 127 дугаар тогтоолоор Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан нийт 1,161,316,214.86 (нэг тэрбум нэг зуун жаран нэгэн сая гурван зуун арван зургаан мянга хоёр зуун арван дөрвөн төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 474,510,317.36 (дөрвөн зуун далан дөрвөн сая таван зуун арван мянга гурван зуун арван долоон төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 дүгээр хавсралтад заасан барилга байгууламж болон дагалдах нийтийн эзэмшлийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 6,483,892.39 (зургаан сая дөрвөн зуун наян гурван мянга найман зуун ерэн хоёр төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 5,926,197.91 (таван сая есөн зуун хорин зургаан мянга нэг зуун ерэн долоон төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

0002193

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 9 дүгээр сарын 09 ны өдрийн
 381 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
		хэмжих нэгж	биет хэмжээ				
1	Албан конторын барилга	м.кв	1512	1980	1,152,231,941.36	466,971,541.19	685,260,400.17
	Барилга байгууламжийн дүн				1,152,231,941.36	466,971,541.19	685,260,400.17
2	Бетон хашаа	м.кв	101.9	1999	4,202,305.34	2,933,915.92	1,268,389.42
3	Төмөр хашаа	м.кв	54.15	1999	2,387,416.05	2,110,308.14	277,107.91
4	Явган хүний зам, талбай	м.кв	76	1999	1,825,352.11	1,825,352.11	-
5	Шилмүүст мод /Гацуур/	ш	1	2002	8,400.00	8,400.00	-
6	Бут сөөг /Буйлс/	ш	1	2002	2,800.00	2,800.00	-
7	Бут сөөг /Тэхийн шээг/	ш	235	2002	658,000.00	658,000.00	-
8	Навчит мод /улиас/	ш	15				
	Нийтийн эзэмшлийн хөрөнгийн дүн				9,084,273.50	7,538,776.17	1,545,497.33
	НИЙТ ДҮН				1,161,316,214.86	474,510,317.36	686,805,897.50
					(нэг тэрбум нэг зуун жаран нэгэн сая гурван зуун арван зургаан мянга хоёр зуун арван дөрвөн төгрөг наян зургаан мянган мөнгө)	(дөрвөн зуун далан дөрвөн сая таван зуун арван мянга гурван зуун арван долоон төгрөг гучин зургаан мянган мөнгө)	(зургаан зуун наян зургаан сая найман зуун таван мянга найман зуун ерэн долоон төгрөг тавин мянган мөнгө)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 05 ны өдрийн
381 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС БАЯНГОЛ, СОНГИНОХАЙРХАН, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Ашиглагд орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
		хэмжих нэгж	биет хэмжээ				
1	Ширээ бор хүрэн	ш	1	2008	1,656,800.00	1,656,800.00	0.00
2	Индэр хурлын	ш	1	2013	450,000.00	225,000.00	225,000.00
3	Тумбочка	ш	1	2003	114,211.36	114,211.36	0.00
4	Бичгийн ширээ	ш	1	2003	205,746.82	205,746.82	0.00
5	Ширээ Бичгийн	ш	1	2006	161,690.00	161,690.00	0.00
6	Тумбочка	ш	1	2006	94,202.00	94,202.00	0.00
7	Тумбочка	ш	1	2003	114,211.36	114,211.36	0.00
8	Бичгийн ширээ	ш	1	2003	205,746.85	205,746.85	0.00
9	Ширээ Бичгийн	ш	2	2006	323,380.00	323,380.00	0.00
10	Тумбочка	ш	2	2006	188,404.00	188,404.00	0.00
11	Ширээ босс	ш	1	2009	1,319,800.00	1,165,823.02	153,976.98
12	Тумбочка	ш	1	2009	309,900.00	276,327.50	33,572.50
13	Шилэн шкаф	ш	1	2009	679,900.00	606,243.85	73,656.15
14	Шкаф	ш	1	2009	659,900.00	588,411.15	71,488.85
					6,483,892.39	5,926,197.91	557,694.48
Тавилга, эд хогшлын нийт дүн							
					(зургаан сая дөрвөн зуун наян гурван мянга найман зуун ерэн хоёр төгрөг гучин есөн мөнгө)	(таван сая есөн зуун хорин зургаан мянга нэг зуун ерэн долоон төгрөг ерэн нэгэн мөнгө)	(таван зуун тавин долоон мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг дөчин найман мөнгө)